ТӨРИЙН ОРДОН

Төрийн ордон

Зорилт:

- Төрийн ордны бүтэц, зохион байгуулалттай танилцах

Сэдвийн агуулга:

- Төрийн ордонтой биечлэн болон цахимаар танилцах
- Төрийн ордны зохион байгуулалт

Сургалтын арга:

- Хэлэлцүүлэг
- Виртуал аялал

Хичээлийн хэрэглэгдэхүүн:

- "Төрийн ордон" видео

Түлхүүр үг:

Төрийн ордон

Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллагууд байнга байрлаж үйл ажиллагаа явуулж байдаг Монголын архитектур, хот байгуулалт, үндэсний түүх соёл, уламжлал, дизайн урлагийн нэгдмэл зохицлыг илэрхийлсэн төрт ёсны хүндэтгэлийн байгууламж.

Төрийн ёслол хүндэтгэлийн цогцолбор

Гадаад орнуудын төр засгийн тэргүүний уулзалт, итгэмжлэх жуух бичиг хүлээн авах, гардуулах ёслол болон төрийн шагнал, одон, медаль гардуулах ёслол зэрэг төрийн хүндэтгэлийн ёслолын арга хэмжээнүүд зохион байгуулагддаг цогцолбор. Төрийн ордны өмнө хэсэгт байрлана.

Хүндэтгэлийн өргөө гэр

Хүндэтгэлийн өргөө гэрийн загварыг монголчуудын төрт ёсны уламжлал, түүхэн замнал, түүний бэлгэдэл, орон зай, интерьерийн оновчтой шийдлийг харгалзан зохиосон. Хүндэтгэлийн өргөө гэрт улс орны томоохон үйл явдал, гадаад улсын болон олон улсын байгууллагын дээд хэмжээний зочин төлөөлөгчдийн айлчлалын үеэр хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагаа зохион байгуулагддаг.

Нэгдсэн хуралдааны танхим

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан зохион байгуулагддаг танхим. Уг танхимыг "Их Хуралдай" танхим гэж нэрлэдэг.

Нэгдсэн хуралдааны танхим

Улсын Их Хурлын Байнгын хорооны хуралдаан зохион байгуулагддаг танхим. "Их эзэн Чингис хаан", "Жанжин Д.Сүхбаатар", "Үндсэн хууль", "Их засаг" гэсэн 4 танхимд Улсын Их Хурлын Байнгын хороод хуралддаг.

Үйл ажиллагаа

1. Сэдэлжүүлэлт

"Төрийн ордон" видеог үзүүлнэ.

2. Шинэ мэдлэг бүтээх

- Сурагчийн гарын авлагаас 7а ангийн сурагчдын Төрийн ордноор хийсэн аяллын талаар танилцуулна.
- "Парламентын боловсрол" цахим хуудсанд зочилж, виртуал аялал хийнэ. Виртуал аяллын дараа сурагчидтай дараах асуудлын хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлнэ.

  - Төрийн ордонд ямар, ямар танхим байдаг вэ?
  - Нэгдсэн хуралдааны танхимын талаар юу мэдэж авсан бэ?
  - УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны танхим яагаад дугуй хэлбэрийн зохион байгуулалттай байдаг вэ?

3. Бататгал

- Дасгал ажлын хуудсыг хувилаад сурагчдад тарааж өгнө.
- Дасгалыг хэрхэн хийх зааврыг танилцуулж, гүйцэтгэх хугацаа олгоно.

Дасгал ажил 1.

Дөрвөлжин шугамтай дэвтэр дээр Төрийн ёслол хүндэтгэлийн цогцолборыг зурна.

Хяналтын асуулт:

1. Төрийн ордныг хэзээ барьж ашиглалтад оруулсан бэ?
2. Төрийн ордонд ямар, ямар байгууллага байрладаг вэ?
3. Төрийн ордонд ямар, ямар танхим байдаг вэ?

Дасгал ажил 1.